



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 493

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
Зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 38 дугаар шийтгэх тогтоолийг үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ганган овогтой Цэрэнлхамын М0003642 серитэй, 0003642 дугаартай сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар хүчингүйд тооцсугай.

2. Г.Цэрэнлхамын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон талаар ёс зүйн мэдээний санд бүртгэн, нийтэд мэдээлэхийг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо (Б.Саранцэцэгт)-д үүрэг болгосугай.

3. Г.Цэрэнлхамын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эрх үүстэл буюу 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг дуустлах хугацаанд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж оруулахгүй байх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т тус тус даалгасугай.



САЙД

УДВАЛ

003080